

Төсөл

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны ,,,, дүгээр сарын ,, ны өдрийн ,, дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ЖЕНДЭРИЙН ЭРХ, ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АЙМГИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Өнөөгийн байдал.

УИХ-аас баталсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль /2011 он/ , Засгийн газрын 2013 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг хэрэгжүүлэх нь Булган аймгийн нутгийн удирдлагын байгууллагын эн тэргүүний чиг үүрэг болж байна.

Аймгийн хэмжээнд улс төр, төрийн ба үйлчилгээний байгууллага, хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн эрх, тэгш байдлын 2013 оны 6 дугаар сарын байдлаар авч үзвэл:

Жендэрийн эрх, тэгш байдлын судалгаа :

д/д	Үзүүлэлт	Тоо	Үүнээс эмэгтэй	Эзлэх хувь /эмэгтэй/	
1	Аймгийн хүн ам	58651	29068	48,5	
2	ЕБС-ийн суралцагсад	9418	4643	49,2	
3	Үүнээс	Бага	4323	2053	47,4
4		Дунд	2973	1446	48,6
5		Ахлах	2122	1144	53,9
6	МСҮТ-д суралцагсад	692	378	54,6	
Дундаж				50.3	
1.Улс төрийн хүрээн дэх жендэрийн байдал					
1	Аймгийн АН-ын хорооны гишүүд	93	37	39,7	
2	Аймгийн МАН-ын хорооны гишүүд	118	31	28,1	
3	Аймгийн ИТХ-ын төлөөлөгч	33	10	30,3	
4	Сумын ИТХ-ын төлөөлөгч	360	133	36,9	
Дундаж				33.7	
2.Төрийн албан дэх жендэрийн эрх, тэгш байдал					
2.1. Улс төрийн албан тушаалтны жендэрийн эрх, тэгш байдал					
1	Аймгийн ИТХ-ын дарга, ЗД, ЗДО	3	-	-	
2	сумын ИТХ-ын дарга	16	5	31,2	
3	Сумын Засаг дарга	16	3	18,7	
4	Сумын Засаг даргын орлогч	16	3	18,7	

5	Багийн засаг дарга	74	13	17,5
6	Багийн ИНХ-ын дарга	74	26	35,1
Дундаж				20,2
2.2. Төрийн захиргааны удирдах албан тушаалтны жендэрийн эрх, тэгш байдал				
1	Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, АЗДТГ-ын дарга, хэлтсийн дарга	21	14	66,6
2	Аймгийн ЗД-ын дэргэдэх агентлагийн дарга	32	10	31,2
3	Сумын ЗДТГ-ын дарга	16	6	37,5
4	Төрийн захиргааны албан хаагчид	202	94	46,5
Дундаж				45,5
2.3. Төрийн үйлчилгээний байгууллагын жендэрийн эрх, тэгш байдал				
2.3.1. Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтны жендэрийн эрх, тэгш байдал				
1	Эрүүл мэндийн салбар	23	19	82,6
2	Боловсролын салбар	91	75	82,4
3	Соёлын салбар	20	11	55,0
Дундаж				73,3
2.3.2. Төрийн үйлчилгээний байгууллагын ажилтнуудын жендэрийн эрх, тэгш байдал				
1	Эрүүл мэндийн салбар	778	536	68,8
2	Боловсролын салбар	1013	736	72,6
3	Соёлын салбар	174	92	52,8
Дундаж				64,7
3. Хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн эрх% тэгш байдал				
1	Хөдөлмөрийн насны хүн ам	42701	21961	51,4
2	Эдийн засгийн идэвхитэй хүн ам	29579	14171	47,9
3	Ажиллагчид	26901	13078	48,6
4	Эдийн засгийн идэвхигүй хүн	13122	7790	59,3
5	Ажилгүй иргэд	2678	1093	40,8
6	Ажиллах хүчний оролцооны түвшин	69,3		64,5
7	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	90,6		92,8
8	Ажилгүйдлийн түвшин	9,1		7,7

Судалгаанаас харахад улс төрийн хүрээнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр хуульд заасан хэмжээнээс 8,7 хувиар өндөр байна. Энэ нь сүүлийн

үед улс төр, нийгмийн харилцаанд эмэгтэйчүүдийн идэвхи оролцоо нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Харин төрийн захиргааны удирдах албан тушаалтны хувьд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 45,5 хувь байгаа нь урд оны мөн үеийнхээс 1,0 хувиар буурсан байна.

Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтны хүрээнд эрүүл мэнд, боловсролын салбарт эмэгтэйчүүдийн эзлэх хувь хуульд зааснаас 33,3 хувиар өндөр байгаа нь тухайн салбарын онцлог бөгөөд цаашид энэ харьцааг бууруулах зорилт тавин ажиллана.

Ажилгүйдэл ядуурлыг бууруулах, өрх толгойлсон эмэгтэйчүүдийг дэмжих, гэр бүлийн хүчирхийлэл, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлалыг арилгах, эрэгтэйчүүдийн боловсролын түвшинг дээшлүүлэх, гэр бүлийн харилцаа болон шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн эрх, тэгш байдлыг хангах шаардлага тавигдаж байна.

Өнөөгийн байдалд дүгнэлт хийж улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш оролцоог хангахад тохиолдож байгаа бэрхшээлийг арилгах, гэр бүлийн хөгжлийг дэмжих, шийдвэр гаргах болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин дэх жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг эн тэргүүнд тавьж байна.

Хөтөлбөрийг аймаг, сум, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, ТББ-ын оролцоотойгоор орон нутгийн хэмжээнд хөрөнгө нөөц бололцоогоо бүрэн ашиглаж хэрэгжүүлнэ.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах үндэслэл:

Жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлал, зарчмыг бүх түвшний бодлогын баримт бичгүүдэд тусгах, түүнд жендэрийн дүн шинжилгээ хийх, жендэрийн мэдрэмжтэй төсөв боловсруулагдахгүй байна.

Бүх нийтийн жендэрийн боловсрол хангалтгүй, ялангуяа төрийн албан хаагчдийн дунд жендэрийн мэдлэг ойлголт сул байна.

Эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн дунд ажилгүйдэл ихэсч, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур амьдралтай байгаа эмэгтэйчүүд, ялангуяа сүүлийн жилүүдэд өрх толгойлсон олон хүүхэдтэй эхчүүдийн тоо нэмэгдэж байна. Эмэгтэйчүүд, охид гэр бүлийн хүчирхийлэлд илүү өртөж байна.

Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, салбарын болон орон нутгийн чадавхи оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Гурав. Хөтөлбөрийн зорилго :

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, стратегийг хэрэгжүүлэх орон нутгийн чадвахийг бий болгох, эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, аймгийн нийгэм эдийн засгийн хөгжил, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцох, хөтөлбөрийн хэрэгжилтэнд иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн оролцоог хангах

замаар жендерийн эрх тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого, үйл ажиллагаанд нэвтрүүлхэд оршино.

Дөрөв. Өөрийн зорилт :

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

Зорилт 1. Жендерийн эрх тэгш байдлын хууль, стратегийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтан, ажилтан, Төрийн бус байгууллагын удирдлага, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг чадавхижуулах, жендерийн мэдээллийн сан бүрдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 4.1.1. Жендерийн эрх тэгш байдлыг хангах хороог байгуулж, гишүүд, орон тооны бус ажилтан, ТББ-ын удирдлагыг чадавхижуулах
- 4.1.2. Орон нутгийн түвшний шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч, хууль хэрэглэгчдэд зориулсан сургалтын хөтөлбөр /модуль/-ийг хэрэгжүүлэх
- 4.1.3. Орон нутгийн бодлого, стратеги, төсөл, хөтөлбөрүүдэд жендерийн дүн шинжилгээ хийх ,
- 4.1.4. Жендерийн асуудлаархи аймаг, сум, байгууллагын мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг бодлого боловсруулахад ашиглах

Хүрэх үр дүн: Жендерийн асуудал хариуцсан салбар хорооны гишүүд, орон тооны бус ажилтан, ТББ-ын удирдлага чадавхижиж , жендерийн мэдээллийн сантай болж, бодлого боловсруулахад ашиглан гарч буй шийдвэрт жендерийн дүн шинжилгээ хийдэг болно. Орон нутгийн бодлого шийдвэрт жендерийн мэдрэмжтэй хандлага бий болсон байна.

Зорилт 2. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Засгийн газрын страегийг сурталчилах, жендерийн сургалт, гэгээрлийн ажлаар олон нийтэд хүйсийн тэнцвэртэй байдлын талаархи зөв ойлголт, хандлагыг төлөвшүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа :

- 4.2.1. Төрийн албан хаагчид, аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдад жендерийн эрх тэгш байдалтай холбоотой хууль, тогтоомж, стратегийг сурталчлах, сургалт зохион байгуулах, зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэгийн түвшинг тогтоох,
- 4.2.2. Насан туршийн боловсролын сургалтыг сум, байгууллагад зохион байгуулан ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглан иргэдэд жендерийн мэдлэг, хандлага, ойлголтыг өөрчлөх , энэ ажилд ТББ-ыг татан оролцуулах, орон нутгийн хэвлэл, мэдээллийн нийтлэлийн бодлогыг жендерийн мэдрэмжтэй болгох , сонин, телевизүүд жендерийн асуудлаар бие даасан булан, тусгай нэвтрүүлэгтэй болох

Хүрэх үр дүн: Байгууллага, орон нутгийн төсвийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах арга зүйтэй болж, төсөв жендэрийн мэдрэмжтэй болно.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат, санхүүжилт :

Хөтөлбөрийн хугацаа: 2013-2016 он

Үе шат : 1 дүгээр үе шат 2013-2014 он

2 дугаар үе шат 2015-2016 он

Хөтөлбөрийн санхүүжилт:

- Улс, орон нутгийн төсөв
- Аж ахуйн нэгж, байгууллагын төсөв
- Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
- Жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сан
- Сум хөгжүүлэх сан
- Төрийн бус байгууллагын гэрээгээр гүйцэтгэх ажлын төсөв
- Олон улсын төсөл хөтөлбөр
- Дэлхийн зөн олон улсын байгуулага
- Бусад эх үүсвэр

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт:

6.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах Монгол улсын хууль, Засгийн газрын стратеги, аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймаг, сумын салбар хороо ажиллана. Салбар хорооны ажиллах журам, бүрэлдэхүүнийг аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчид баталж, аймаг, сумын Засаг дарга нар ахалж ажиллана.

6.2. Аймаг, сумын салбар хорооны нарийн бичгийн даргаар аймагт Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн нийгмийн халамж, хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн, суманд Нийгмийн ажил, халамж үйлчилгээний ажилтан ажиллана. Нарийн бичгийн дарга нарт ажлын үр дүнг харгалзан тухайн байгууллагын цалингийн санд багтаан улирлаар урамшуулал өгч болно. Урамшууллын хэмжээг салбар хорооны хурлаар тогтооно.

6.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг хэвлэл мэдээлэл, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

6.4. Жендэрийн мэдээллийн нэгдсэн сан, хүйсээр ангилсан статистикийн мэдээг ил тод болгож, хэрэглэгчдэд цахим хэлбэрээр хүргэнэ.

6.5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг аймаг, сумын салбар хорооны дарга төсөвт тусгуулан аймаг, сумын ИТХ-ын хуралдаанаар батлуулна.

Долоо. Хөтөлбөрийн тайлан, хяналт шинжилгээ, үнэлгээ :

7.1. Жендэрийн эрх тэгш байдлын хууль, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан аймаг, сумын салбар хорооны хурлаар хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж гаргана .

7.2. Жендэрийн эрх тэгш байдлын хууль, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг 2 жил тутамд 1 удаа хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэнэ. Хяналт шинжилгээ, үнэлгээг хөндлөнгийн мэргэшсэн байгууллагаар хийлгэнэ.

7.3. Жендэрийн хууль, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тухай аймаг, сумын Засаг даргын тайланг 2 жил тутамд 1 удаа аймаг, сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэн, дүнг нийтэд мэдээлнэ.

7.4. Жендэрийн хууль, стратеги, хэрэгжилтийн тайлан, ажиллагсадын хүйсийн тайланг хугацаанд нь бүх шатанд гаргаж тайлагнана. Жендэрийн хуулийн тайлан мэдээний цаглабарыг хавсаргав.

7.5. Жендэрийн эрх тэгш байдлын хууль, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайн зохион байгуулж үр дүнд хүрсэн нутгийн удирдлагын байгууллага, аж ахуйн нэгж, ТББ, иргэнийг 2 жил тутамд 1 удаа шалгаруулж урамшуулна.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд байгууллагуудын

хүлээх үүрэг:

1. Аймгийн засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс :
2. Сумын Засаг даргын тамгын газар :
 - Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааны чиглэл, арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
 - Жендэрийн хууль, стратеги, хөтөлбөрийг хэрэгжүүлж хийсэн Засаг даргын тайланг бэлтгэн, сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн, үнэлэлт дүгнэлт өгүүлэх
 - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагааг эрхэлж, түүнийг хэрэгжүүлэхэд зориулж байгаа хөрөнгийг үр ашигтай зарцуулах
 - Сумдын нийгмийн ажилтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.
3. Хөтөлбөрийн үр дүнг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор тайлагнаж цаашид авах арга хэмжээний талаар саналаа аймаг, сумын салбар хороонд ирүүлнэ Статистикийн хэлтэс : Жендэрийн статистикийн мэдээллийн аймаг, сумын нэгдсэн санг бүрдүүлж, түүнийг бүх шатны бодлого боловсруулахад ашиглах боломжийг бүрдүүлэх
4. Эрүүл мэндийн газар : Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг нөхөн үржихүйн болон эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, эрүүл мэндийн салбар дах жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх
5. Боловсрол соёлын газар: Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн бүх шатны боловсрол эзэмших, мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, насан туршийн тасралтгүй

боловсролын сургалтанд хамрагдах боломжийг бүрдүүлж, сурууль завсардалтыг арилгах, боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх

6. Хөдөлмөрийн хэлтэс : Хөдөлмөрийн харилцаан дэх хүйсийн ялгаварлалт, тухайлбал: эмэгтэйчүүдийн албан ёсны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх эрхэд харшилсан нас, хүйс, биеийн тусгайлсан онцлог, жирэмслэхгүй байхыг тулгах зэрэг эрх тэгш байдлын зөрчлийг арилгах, түүнд чиглэсэн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах
7. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс: Гэр бүл дэх жендэрийн эрх тэгш байдалд үнэлгээ хийж, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, залуучуудыг гэр бүлд бэлтгэх, гэр бүлийн боловсролыг олгох, гэр бүлээ хөгжүүлэх, гэр бүлийн харилцааг төгөлдөржүүлэхэд эрэгтэй эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах, эдгээрт чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах
8. Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс: Нийгмийн халамийн үйлчилгээнд зорилтот бүлгийн иргэдийг тэгш хамруулах, гэр бүлийн хүрээнд хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамж, үйлчилгээний хөдөлмөрийн үнэлгээг чанаржуулах
9. Сумын Засаг даргын тамгын газар :
 - Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааны чиглэл, арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
 - Жендэрийн хууль, стратеги, хөтөлбөрийг хэрэгжүүлж хийсэн Засаг даргын тайланг бэлтгэн, сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн, үнэлэлт дүгнэлт өгүүлэх
 - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагааг эрхэлж, түүнийг хэрэгжүүлэхэд зориулж байгаа хөрөнгийг үр ашигтай зарцуулах
 - Сумдын нийгмийн ажилтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.
 - Хөтөлбөрийн үр дүнг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор тайлагнаж цаашид авах арга хэмжээний талаар саналаа аймайг, сумын салбар хороонд ирүүлнэ.
10. Төрийн бус байгуулага: Жендэрийн хууль тогтоомж, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтэнд мониторинг, судалгаа явуулж, жендэрийн асуудал хариуцсан ажилтан, иргэд олон нийтэд сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах

Ес. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт :

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

1. Жендэрийн эрх тэгш байдлын нэгдсэн мэдээллийн сантай болсон байх

2. Хүйсээр нь ангилсан мэдээ мэдээлэл бүхий жендэрийн тоо баримт багтаасан мэдээллийн эмхтгэлийг жил бүр гаргасан байх
3. Сум орон нутагт зохион байгуулсан сургалт, сургалтанд хамрагдсан хүний тоо өссөн байх
4. Хөтөлбөрийг хэрэгжүүлж зарцуулсан хөрөнгө /аймаг, сум, байгууллагаар/ өссөн байх
5. Хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдийн тоо буурсан байх
6. Сургууль завсардалт буурч, МСҮТ, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дотор эрэгтэй сурагчдын эзлэх хувь өссөн байх
7. Жендэрийн хөгжлийн индекс өссөн байх
8. Жендэрийн хууль, стратеги, хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлж аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажилласан ТББ-ын тоо жил нэмэгдсэн байх
9. Хүн амын өсөлт ...0,1 хувиар нэмэгдэж, дундаж наслалт өсч, цаг бус нас баралтыг бууруулна.
10. Гэр бүл салалтын тоо буурсан байх

Жендэрийн эрх, тэгш байдлын тоон шалгуур үзүүлэлт:

д/д	Үзүүлэлт	Хуульд заасан нь	Суурь үзүүлэлт 2012 он	Хүрэх түвшин	
				2014 он	2016 он
1. Улс төрийн хүрэн дэх жендэрийн байдал					
1.1	Аймгийн АН-ын хорооны гишүүд	25,0-аас доошгүй	39.7	39.7	39.7
1.2	Аймгийн МАН-ын хорооны гишүүд		28.1	28.1	28.1
2. Төрийн албан дэх жендэрийн эрх, тэгш байдал					
2.1. Улс төрийн албан тушаалтны жендэрийн эрх, тэгш байдал					
2.1.1	Аймгийн ИТХ-ын дарга, ЗД, ЗДО	15-аас доошгүй	-	10.0	11.0
2.1.2	сумын ИТХ-ын дарга	25,0-аас доошгүй	31.2	31.2	31.2
2.1.3	Сумын Засаг дарга		18.7	19.0	20.0
2.1.4	Сумын Засаг даргын орлогч		18.7	19.0	20.0
2.1.5	Багийн засаг дарга		17.5	18.0	19.0
2.2. Төрийн захиргааны удирдах албан тушаалтны жендэрийн эрх, тэгш байдал					
2.2.1	АЗДТГ-ын дарга, хэлтсийн дарга	40,0-өөс доошгүй	28.0	29.0	30.0
2.2.2	Аймгийн ЗД-ын дэргэдэх агентлагийн дарга		31.2	32.0	33.0
2.2.3	Сумын ЗДТГ-ын дарга		18.7	19.0	20.0
2.3. Төрийн үйлчилгээний байгууллагын					

жендэрийн эрх, тэгш байдал					
2.3.1. Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтны жендэрийн эрх, тэгш байдал					
2.3.1.1	Эрүүл мэндийн салбар	40:60	82:18	74:26	65:35
2.3.1.2	Боловсролын салбар		82:18	70:30	68:32
2.3.1.3	Соёлын салбар		55:45	52:48	50:50
2.3.2. Төрийн үйлчилгээний байгууллагын ажилтнуудын жендэрийн эрх, тэгш байдал					
2.3.2.1	Эрүүл мэндийн салбар	40:60	68:32	66:34	64:36
2.3.2.2	Боловсролын салбар		72:28	70:30	68:32
2.3.2.3	Соёлын салбар		52:48	50:50	50:50
2.4. Суралцагчдын жендэрийн эрх тэгш байдал					
2.4.1	ЕБС-ийн суралцагч	9418	49,2		
2.4.2	Үүнээс	4323	47,4		
2.4.3		2973	48,6		
2.4.4		2122	53,9		
2.4.5	МСҮТ-ийн суралцагч	692	54,6		
2.5. Хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн эрх тэгш байдал					
2.5.1	Хөдөлмөрийн насны хүн ам	42701	51,4		
2.5.2	Эдийн засгийн идэвхитэй хүн ам	29579	47,9		
2.5.3	Ажиллагчид	26901	48,6		
2.5.4	Эдийн засгийн идэвхигүй хүн	13122	59,3		
2.5.5	Ажилгүй иргэд	2678	40,8		
2.5.6	Ажиллах хүчний оролцооны түвшин	69,3	64,5		
2.5.7	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	90,6	92,8		
2.5.8	Ажилгүйдлийн түвшин	9,1	7,7		

----- о О о -----

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны ,,,, дүгээр сарын ,, ны өдрийн ,, дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**“ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АЙМГИЙН ХӨТӨЛБӨР”-ИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
/2013-2016 он/**

№	Зорилт арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах албан тушаалтан	Хамтран ажиллах Байгууллага	Төсвийн төсөөлөл /сая/		
					Улсын төсөв	Орон нутгийн хөгжлийн сан	
	аймаг	сум					
Зорилт 1. Жендэрийн эрх тэгш байдлын хууль, стратегийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хороог байгуулж, албан тушаалтан, ажилтан, хамтран хэрэгжүүлэх, хяналт тавих Төрийн бус байгууллагын удирдлага, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг чадавхижуулах, жендэрийн мэдээллийн сан бүрдүүлэх							
1.1	Жендэрийн асуудал эрхэлсэн аймаг, сумын хороодыг байгуулах, хорооны ажиллах дүрмийг батлах, нарийн бичгийн дарга нарыг урамшуулалтай болгох	2013 он	Салбар хороо	НХҮХ ХГБХХ			
1.2	Жендэрийн асуудал хариуцсан орон тооны бус ажилтныг аймаг, сум, байгууллагуудад томилуулах, ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтыг боловсруулан хүргүүлэх, сургалтанд хамруулах	2013 он	Салбар хороо	НХҮХ ХГБХХ			
1.3	Жендэрийн асуудал эрхэлсэн аймаг, сумын хорооны гишүүдийг чадавхижуулах үе шаттайгаар сургалтанд хамруулах	2013-2016 он	Салбар хороо	НХҮХ ХГБХХ		2,0 x2	
1.4	Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, сумын ЗДТГ-ын дарга, байгууллагын дарга нарт зориулсан сургалтын хөтөлбөр гаргах, шаталсан сургалтыг зохион байгуулах	2014 ,2016 он	Салбар хороо НХҮХ Ш.Оюумаа	ХГБХХ, ТББ		2.0	0,5x2
1.5	Сумын Нийгмийн ажилтнуудыг жендэрийн асуудлаар мэргэшүүлэх сургалтанд үе шаттайгаар хамруулах	2013-2015 онд 3 удаа	Салбар хороо НХҮХ Ш.Оюумаа	ХГБХХ	2,0x3		
1.6	Орон нутгийн бодлого, стратеги, төсөл, хөтөлбөрүүдэд жендэрийн дүн шинжилгээ,	2014 он	Салбар хороо	ХГБХХ, ТББ		1.0	1,0

	судалгаа хийх ажилд ТББ-уудыг сургаж, дадлагажуулах, шаталсан сургалтыг Үндэсний хороотой хамтран зохион байгуулах		НХҮХ Ш.Оюумаа					
1.7	Нутгийн удирдлагын байгууллагуудын шийдвэрт жендэрийн үнэлгээ хийх аргачлал, шалгуур үзүүлэлтийг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулан, мөрдөх	2014 оны 1, 4-р улирал	Салбар хороо	ИТХ-ын ажлын алба				
1.8	Орон нутгийн бодлого, стратеги, төсөл, хөтөлбөрүүдэд жендэрийн дүн шинжилгээ хийх ажлыг ТББ-уудаар хийлгэх	2014 оны 1-2-р улирал	Салбар хороо НХҮХ Ш.Оюумаа	ХГБХХ				
1.9	Жендэрийн асуудлаар орон нутгийн түвшинд хүйсээр ангилсан статистикийн мэдээ гарган аймаг, сум, байгууллагын мэдээллийн сан бүрдүүлэх, сангийн мэдээллийг ил тод болгон мэдээлэх, түүнийг бодлого боловсруулахад ашиглах	Жил бүр	СХ Б.Цолмонбаяр	НХХ				
1.10	Хүйсээр ангилсан мэдээ, мэдээлэл, статистикийн үзүүлэлт бүхий жендэрийн мэдээллийн эмхтгэл гаргах	Жил бүрийн 1-р сар	СХ Б.Цолмонбаяр	НХХ		0,5		
1.11	Улс төрийн намууд, төрийн захиргаа, төсөвт байгууллага, ААНБ зэрэг салбарын онцлогт тохирсон жендэрийн судалгаа хийх арга зүй, аргачлалд ТББ-уудыг мэргэжүүлэх, сургалтанд хамруулах	2014, 2015 он	АИТХТ-ийн н/б дарга	Хууль зүйн хэлтэс		2,0		2,0
1.12	Жендэрийн мэдээ мэдээлэл, статистикийн мэдээг байгууллагууд хугацаанд нь Статистикийн хэлтэст хүргүүлж байх	Жил бүрийн 12-р сар	Ерөнхий менежерүүд	Статистикийн хэлтэс				
1.13	Жендэрийн асуудлаар сургалт явуулах аймаг, сумын сургагч багш нарыг бэлтгэх, эрх олгох	2013-2014	Салбар хороо	НХҮХ ХГБХХ		2,0	1,0	1,0
Зорилт 2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Засгийн газрын стртаегийг сурталчилах, олон нийтэд хүйсийн тэнцвэртэй байдлын талаархи зөв ойлголт, хандлагыг төлөвшүүлэх								
2.1	Төрийн албан хаагчид, аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдад жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой хууль, тогтоомж, стратегийг сурталчлах, сургалт зохион байгуулах, зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэгийн түвшинг тогтоох	2014-2016	Ерөнхий менежерүүд	Хууль зүйн хэлтэс				
2.2	Жендэрийн асуудлаар иргэд, олон нийтийн мэдлэг, хандлага, ойлголтыг өөрчлөх, жендэрийн	Жил бүр	Салбар хороо	Хууль зүйн хэлтэс		2,0		

	боловсролыг дээшлүүлэх нөлөөлөл , сурталчилгааны ажлыг ТББ-аар гэрээгээр гүйцэтгүүлэх							
2.3	орон нутгийн хэвлэл, ТВ-үүд мэдээлэл нийтлэлийн бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгох , жендэрийн асуудлаар бие даасан булан, тусгай нэвтрүүлэгтэй болох	2013 -2016 он	Сонин ТВ-ын удирдлага	Хэвлэл мэдээллийн алба				
2.4	Сэтгүүлч, сурвалжлагч нарыг жендэрийн асуудлаар мэргэшүүлэх сургалтанд хамруулах	2014-2016	Сонин ТВ-ын удирдлага	Хэвлэл мэдээллийн алба		2,0		
2.5	Олон нийтэд хуулийг сурталчлах хялбарчилсан мэдээлэл , гарын авлага бэлтгэн тараах	2013,2014 он	ХЗХ П.Хишигдаваа	ХМ алба	1,0	1.0		
2.6	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, стратеги, аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах талаар олон нийтийн хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулах	Жил бүр	Хэвлэл мэдээллийн алба	Хуул зүйн хэлтэс				
2.7	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны тайлан мэдээг ТББ-уудаар хэлэлцүүлэх	Жил бүрийн 3-р сар	Салбар хороо	НХҮХ				
Зорилт 3. Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, жендэрийн шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтыг улс төр, нийгэм эдийн засаг, хөдөлмөр, гэр бүлийн харилцаанд хориглох, түүнээс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлэх								
3.1	Төрийн байгууллага, ажил олгогчид Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг ажилтнууддаа мэдээлж байх	Жил бүр	Ерөнхий менежерүүд	Сумын ЗД				
3.2	Төрийн байгууллага, ажил олгогчид бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг нээлттэй мэдээлэх	2014 оноос эхлэн жил бүр	ХЗХ	Сумын ЗД				
3.3	Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээ, байгууллагын дотоод журамд тусгах тухай зөвлөмж гарган нэгж байгууллагуудад хүргүүлэх	2013 оны 4-р улиралд	Салбар хороо	НХҮХ ХЗХ				
3.4	Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай иргэний гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх удирдамжийг хэрэгжүүлэх	Жил бүр	Салбар хороо	НХҮХ				

3.5	Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсэн тухай иргэний гомдлыг шийдвэрлэх арга зүйд орон тооны бус ажилтнуудыг сургах дадлагажуулах	Жил бүр	Салбар хороо	НХҮХ		2,0		
3.6	Орон нутгийн сонгуульд оролцогчдын хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахад анхаарч ажиллах /ялангуяа эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх	Сонгуульд бэлтгэх хугацаанд	Улс төрийн намууд	ХЗХ				
Зорилт 3.1. Төрийн алба дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар								
3.1.1	Судалгаа хийж хүйсийн харьцаа алдагдсан салбаруудын мэдээллийг гаргах, нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлох	Жил бүр	НХХ Г.Ганбаатар	НХҮХ				
3.1.2	Төрийн албан хаагчдын хүйсийн төлөөллийн доод хязгаарын заалтыг хангах арга хэмжээний удирдамжийг гарган хэрэгжүүлэх	2014 он	ЭМГ СГ, ХХААЖДҮГ ССАЖГ	Салбар хороо				
3.1.3	Аймаг, сумын ИТХ, Засаг дарга, Тамгын газрын дэргэдэх хороо, зөвлөл, комисс, орон нутгийн өмчид ААНБ-ын ТУЗ зэрэг хамтын удирдлагын байгууллагын хүйсийн харьцааны судалгааг гаргах	2013 оны 2-р улирал	НХХ Г.Ганбаатар	НХҮХ				
3.1.4	Удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын шалгалтын агуулгад жендэрийн эрх тэгш байдлын тухай оруулах	2013, 2014 онд	ТЗУХ М.Батжаргал	Төрийн албаны СЗ				
3.1.5	Хүний нөөцийн талаарх бодлогод жендэрийн асуудлыг тусган хэрэгжүүлэх	Жил бүр	ТЗУХ М.Батжаргал	ЭМГ, БГ ССАЖГ				
3.2 Хөдөлмөрийн харилцааг жендэрийн мэдрэмжтэй болгох талаар								
3.2.1	Бага насны хүүхдэдтэй эцэг эхийг дэмжих хөтөлбөртэй болгох талаар ААНБ-ын удирдлагад чиглэл өгч хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээ, дотоод журамд нь тусгуулах арга хэмжээ авах	2013-2016 он	Салбар хороо	НХҮХ				
3.2.2	Албан бус ажил эрхлэлтийн өнөөгийн байдалд аймгийн үзлэг хийж нэгдсэн судалгааг гаргах, хүйсийн харьцааг тогтоох, ялангуяа малчдын хөдөлмөр эрхлэлтэнд үнэлэлт дүгнэлт өгөх	2014 он	ХХ, ХХААЖДҮГ Батболд О.Гантулга	Статистикийн хэлтэс				
3.2.3	Хүүхэд, ахмад настан, ХБИ-дийн асрамж зэрэг үнэлгээгүй хөдөлмөрийг үнэлэх аргачлалыг хэрэгжүүлэх	2014 он	ХХ Батболд	Хөдөлмөрийн яам				

3.2.4	Ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах, гомдлыг хянан шийдвэрлэх асуудлыг байгууллагын дотоод журамд тусгуулах талаар зөвлөмж гарган хүргүүлэх, дагаж мөрдөж байгааг хянан шалгах	2013-2014 он	ХЗХ П.Хишигдаваа	МХГ, ХХ				
3.2.5	Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний судалгаа мэдээг хүйсээр ялган гаргах	Жил бүр	СХ Б.Цолмонбаяр	ХХ Батболд				
3.2.6	Хөдөлмөрийн харьцаан дах жендэрийн эрх тэгш байдлыг хангаж буйд чиглэсэн хяналт, шалгалтын ажлыг бүх шатанд зохион байгуулах	Жил бүр	МХГ Д.Эрдэнэбаяр	ХХ Батболд				
3.2.7	Эмэгтэйчүүдийн албан ёсны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжийг судлан гэрээр буюу гэрээгээр, цагаар ажиллуулах хэлбэрийг бодлогын хувьд дэмжих	2014-2016 он	ХХ Батболд	Аймгийн ЭЗ Ч.Оюун				
3.2.8	Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгааг гаргах, өрхийн үйлдвэрлэлд эрэгтэй, эмэгтэйчүүдийг эрх тэгш оролцуулах зөвлөмж гаргах	2014 он	ХХ Батболд	Аймгийн ЭЗ Ч.Оюун				
3.2.9	Банк санхүүгийн салбарын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдэд ээлтэй жижиг зээлийн шинэ төрөл, хэлбэрийг нэвтрүүлэх	2013 -2016 он	ХХ Батболд Банкны захирлууд	Аймгийн ЭЗ Ч.Оюун				

3.3 Гэр бүлийн харилцаан дах жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар

3.3.1	Гэр бүлийн өмчлөх эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийн харилцаанд жендэрийн дүн шинжилгээ хийж, тэгш байдлыг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах	2013-2016 он	УБХ ХХ	ХЗХ				
3.3.2	Өрх толгойлсон олон хүүхэдтэй, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой эцэг эхчүүдийг дэмжих сум, байгууллагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2013-2016 он	НХҮХ Ш.Оюумаа	СЗДТГ				
3.3.3	Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн гэр бүлийн хөгжилд эрх тэгш оролцоход чиглэсэн нөлөөлөл, сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлэх	2013-2016 он	ХГБХХ Д.Оюунбилэг	НХҮХ Ш.Оюумаа Аймгийн ЭЗ Ч.Оюун ТББ				
3.3.4	Гэр бүлийн хүчирхийлэл дэх хохирогчдыг хамгаалах байр, сэтгэл зүйн үйлчилгээг аймгийн төвд бий болгох	2013-2016 он	П.Хишигдаваа ХЗХ Д.Оюунбилэг	НХҮХ Ш.Оюумаа, Аймгийн ЭЗ				

			ХГБХХ О.Ганбат ЦХ	Ч.Оюун				
3.3.5	Өсвөр үе, залуучуудад гэр бүлийн боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гэр бүлийн хөгжлийн сургагч багш нарыг бэлтгэх	2013-2016 он	ХГБХХ Д.Оюунбилэг	НХҮХ Ш.Оюумаа ТББ				
3.3.6	"Аудёүб ,пёіёіі 0дā ⁰⁰ "-а сумдад байгуулах	2013-2016 он	Сумын 3Д нар	ХГБХХ Д.Оюунбилэг				
3.3.7	Манлайлагч эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулах	2014 он	ХГБХХ Д.Оюунбилэг Сумын 3Д нар	НХҮХ Ш.Оюумаа ТББ, Аймгийн ЭЗ Ч.Оюун		5,0		0,5
3.3.8	Эрэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулах	2015 он	ХГБХХ Д.Оюунбилэг Сумын 3Д нар	НХҮХ Ш.Оюумаа ТББ		5,0		
3.3.9	Эрэгтэйчүүдийг жендэрийн сургалтанд хамруулах	2015 он	Сумын 3Д нар	ХГБХХ				
3.3.10	Удамшлын доголдол, оюун ухааны хомсдолоос хамгаалан "Угийн бичиг" хөтлөх бэлтгэл ажлыг хангаж, эхлүүлэх	2014 оноос	ССАЖГ	СЗД		3,0		
3.3.11	"Гэр бүлийн хөгжилд жендэрийн тэгш байдлыг хангах нь" сэдвээр иргэд олон нийтэд мэргэшсэн лекторуудаар сургалт, лекц, уулзалт ярилцлага зохион байгуулах	2014, 2015 он	ХГБХХ Д.Оюунбилэг Сумын 3Д нар	НХҮХ Ш.Оюумаа ТББ, Аймгийн ЭЗ Ч.Оюун		2,0x2		
3.3.12	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх сургалтыг зохион байгуулах, хялбарчилсан мэдээлэл, гарын авлагаар хангах	2013-2016 он	ХГБХХ Д.Оюунбилэг Сумын 3Д нар	НХҮХ Ш.Оюумаа ТББ, Аймгийн ЭЗ Ч.Оюун		1,0x2		
3.4 Эрүүл мэндийн салбар дах жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар								
3.4.1	Эрүүл мэндийн салбарт судалгааг гаргаж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой хууль, тогтоомж, стратегийг сурталчлах сургалт зохион байгуулах, зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэгийн түвшинг тогтоох	2013-2016 он	ЭМГ С.Нарантуяа	НХХ Н.Алтайбаатар				

3.4.2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомж, стратеги, аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллах	2013-2016 он	ЭМГ С.Нарантуяа	НХХ Н.Алтайбаатар				
3.4.3	Эрэгтэйчүүдийн эмчийг бэлтгэх, ажиллах нөхөцөл бололцоогоор хангах	2013-2016 он	ЭМГ С.Нарантуяа	НХХ Н.Алтайбаатар				
3.4.4	Эрэгтэйчүүдийн нас баралтанд нөлөөлж байгаа хүчин зүйлийг судлах, тэдгээрийг арилгах арга хэмжээ авах	2013-2016 он	ЭМГ С.Нарантуяа	НЭ СЭМТ				
3.4.5	Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дунд зонхилон тохиолдож нас барж байгаа өвчлөлтэй тэмцэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2013-2016 он	СЗД, ЭМГ С.Нарантуяа	НХХ Н.Алтайбаатар				
3.4.6	Гэр бүлийн эрүүл мэндийн боловсрол хөтөлбөрийг аймаг, суманд хэрэгжүүлэх, НҮЭМ, эрүүл аж төрөх ёсны тулгамдсан асуудлаар эрэгтэй, эмэгтэйчүүдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг аймаг, суманд хэрэгжүүлэх	2013-2016 он	СЗД, ЭМГ С.Нарантуяа	НХХ Н.Алтайбаатар				
3.4.7	Зорилтот бүлэгт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх хөтөлбөрийг аймаг, суманд хэрэгжүүлэх	2013-2016 он	СЗД, ЭМГ С.Нарантуяа	НХХ Н.Алтайбаатар				

3.5 Боловсролын салбар дах жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар

3.5.1	Цэцэрлэг, сургууль, МСҮТ-ийн багш нарт жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой хууль, тогтоомж, стратегийг сурталчлах сургалт зохион байгуулах, зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэгийн түвшинг тогтоох	2013-2016 он	БГ Д.Цогоо	НХХ Т.Дорж				
3.5.2	Жендэрийн асуудлаар бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх нөлөөлөл, гэгээрэл сурталчилгааны ажлыг ТББ-аар гүйцэтгүүлэх	2013-2016 он	БГ Д.Цогоо	НХХ Т.Дорж				
3.5.3	Сумын Гэрээлэл төвийн насан туршийн тасралтгүй боловсролыг эрэгтэй, эмэгтэй тэгш хүртэх боломжоор хангах	2013-2016 он	БГ Д.Цогоо	НХХ Т.Дорж				
3.5.4	Сургалтын орчинг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгаж, жендэрийн сургалт, гэгээрлийн үйл ажиллагааг хөтөлбөр, төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах	2013-2016 он	БГ Д.Цогоо	НХХ Т.Дорж				
3.5.5	Боловсролын салбар, байгууллагын тайланд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан ажлын үр дүнг заавал оруулан тайлагнах	2013-2016 он	БГ Д.Цогоо	НХХ Т.Дорж				

3.5.6	Сургууль, цэцэрлэгийн захирал эрхлэгч нарын ажлыг үнэлэх дүгнэх үзүүлэлтэд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар хийсэн ажлын дүнг оруулж байх	2013-2016 он	БГ Д.Цогоо	НХХ Т.Дорж				
3.5.6	Сургуулийн төсөлт хичээлийн агуулгад суралцагчийн эзэмшвэл зохих жендэрийн эрх тэгш байдлын агуулгыг оруулан мэдлэг олгож байх	2013-2016 он	БГ Д.Цогоо	НХХ Т.Дорж				
Зорилт 4. Жендэрийн мэдрэмжтэй төсөв зохиох арга зүйг байгууллага, орон нутгийн төсвийг боловсруулах , батлахад нэвтрүүлэх								
4.1	Төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагч , ажил олгогч, төсвийн мэргэжилтэн, төрийн сангийн ажилтан нарыг жендэрийн мэдрэмжтэй төсөв зохиох арга зүйн сургалтанд үе шаттайгаар хамруулах, зөвлөмж, гарын авлагаар хангах	2013-2016 он	СТСХ О.Наранжаргал	Салбар хороо		1,0x2		
4.2	Байгууллага, орон нутгийн төсөв нь жендэрийн мэдрэмжтэй байгаа эсэхэд хяналт шинжилгээг ТББ-аар хийлгэж, үнэлэлт дүгнэлт өгүүлэх	2013-2016 он	Салбар хороо	СТСХ				
4.3	Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг аймаг, сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд төсөв нь жендэрийн мэдрэмжийн үнэлгээ дүгнэлтийг хамт оруулж байх	2013-2016 он	СТСХ О.Наранжаргал	Салбар хороо				
	Нийт хөрөнгө оруулалтын дүн				7,0 сая	39,5 сая	2,0 сая	4,5 сая

**“ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АЙМГИЙН ХӨТӨЛБӨР”-ИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ
/2013-2016 он/**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шаардагдах төсөв		
		Улсын төсөв	Орон нутгийн хөгжлийн сан	Төсөл хөтөлбөр
1	Жендэрийн асуудал эрхэлсэн аймаг, сумын хорооны гишүүдийг чадавхижуулах үе шаттайгаар сургалтанд хамруулах		2,0x2	
2	Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, сумын ЗДТГ-ын дарга, байгууллагын дарга нарт зориулсан сургалтын хөтөлбөр гаргах, шаталсан сургалтыг зохион байгуулах		2,0	0,5x2
3	Сумын Нийгмийн ажилтнуудыг жендэрийн асуудлаар мэргэшүүлэх сургалтанд үе шаттайгаар хамруулах	2,0x3		
4	Орон нутгийн бодлого, стратеги, төсөл, хөтөлбөрүүдэд жендерийн дүн шинжилгээ, судалгаа хийх ажилд ТББ-уудыг сургаж, дадлагажуулах, шаталсан сургалтыг Үндэсний хороотой хамтран зохион байгуулах		1,0	1,0
5	Хүйсээр ангилсан мэдээ, мэдээлэл, статистикийн үзүүлэлт бүхийи жендэрийн мэдээллийн эмхтгэл гаргах		0,5	
6	Улс төрийн намууд, төрийн захиргаа, төсөвт байгууллага, ААНБ зэрэг салбарын онцлогт тохирсон жендэрийн судалгаа хийх арга зүй, аргачлалд ТББ-уудыг мэргэжүүлэх, сургалтанд хамруулах		2,0	2,0
7	Жендэрийн асуудлаар сургалт явуулах аймаг, сумын сургагч багш нарыг бэлтгэх, эрх олгох		2,0	1,0
8	Жендэрийн асуудлаар иргэд, олон нийтийн мэдлэг, хандлага, ойлголтыг өөрчлөх, жендэрийн боловсролыг дээшлүүлэх нөлөөлөл, сурталчилгааны ажлыг ТББ-аар гэрээгээр гүйцэтгүүлэх		2,0	
9	Сэтгүүлч, сурвалжлагч нарыг жендэрийн асуудлаар мэргэшүүлэх сургалтанд хамруулах		2,0	
10	Олон нийтэд хуулийг сурталчлах хялбарчилсан мэдээлэл,	1,0	1,0	

	гарын авлага бэлтгэн тараах				
11	Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай иргэний гомдлыг шийдвэрлэх арга зүйд орон тооны бус ажилтнуудыг сургах дадлагажуулах		2,0		
12	Манлайлагч эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулах		5,0		0,5
13	Эрэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулах		5,0		
14	Удамшлын доголдол, оюун ухааны хомсдолоос хамгаалан “Угийн бичиг” хөтлөх бэлтгэл ажлыг хангаж, эхлүүлэх /тусгай хөтөлбөрөөр/		3,0		
15	“Гэр бүлийн хөгжилд жендэрийн тэгш байдлыг хангах нь” сэдвээр иргэд олон нийтэд мэргэшсэн лекторуудаар сургалт, лекц, уулзалт ярилцлага зохион байгуулах		2,0x2		
16	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх сургалтыг зохион байгуулах, хялбарчилсан мэдээлэл, гарын авлагаар хангах		1,0x2		
17	Төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагч, ажил олгогч, төсвийн мэргэжилтэн, төрийн сангийн ажилтан нарыг жендэрийн мэдрэмжтэй төсөв зохиох арга зүйн сургалтанд үе шаттайгаар хамруулах, зөвлөмж, гарын авлагаар хангах		1,0x2		
18	Хөрөнгө оруулалтын дүн	7,0 сая	39,5 сая	2,0 сая	4,5 сая
19	Нийт дүн		53,0 сая		

